



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

17 дугаар цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ОРА-2022 /83/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn Эрдэнэт хот 2022 он</p>	<p>Орхон аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: Ц.Нармандах Утас: 70353088 Цахим хаяг: narmandakhts@audit.gov.mn</p> <p>Аудитын менежер: Б.Эрдэнэ Утас: 70355805 Цахим хаяг: erdeneb@audit.gov.mn</p> <p>Аудитор: Б.Бямбатогтох Утас: 70350757 Цахим хаяг: byambatogtokhb@audit.gov.mn</p>
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1. Аудитын санал дүгнэлт	2-3
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	4
3. Аудитын тайлан	10
3.1 Ерөнхий зүйл	10
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	11
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	12
3.4 Материаллаг байдал	12
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	12
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	12
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг	14
3.8 Аудитын гол асуудал	14
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	14
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	14
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал	14
4. Аудитын илрүүлэлт	15
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	16

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ



ОРХОН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

61033 Орхон аймаг, Баян-Өндөр сум,
Урт булаг баг, Ханддоржийн
гудамж, Утас/Факс: 70359826
Цахим шуудан: orkhon@audit.gov.mn

2022.02.25 № 10

танай _____ -ны № _____ -г

ОРХОН АЙМГИЙН 17 ДУГААР
ЦЭЦЭРЛЭГИЙН ЭРХЛЭГЧ
Н.ЯНЖИНЛХАМ

Аудитын санал дүгнэлт

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу 17 дугаар цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

17 дугаар цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

D:\my doc \alban bichig\ 2022-A4.doc

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРМАНДАХ

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	83,931,069.83	80,702,159.83
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	415.00	415.00
311	Кассанд байгаа бэлэн мөнгө	415.00	415.00
31130	Нэмэлт санхүүжилт	415.00	415.00
33	АВЛАГА	592,028.00	592,028.00
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага	592,028.00	592,028.00
35	БАРАА МАТЕРИАЛ	83,338,626.83	80,109,716.83
351	Түүхий эд материал	73,396,355.76	73,142,655.76
35110	Тусгай зориулалттай материал	73,396,355.76	73,142,655.76
354	Хангамжийн материал	9,942,271.07	6,967,061.07
35410	Бичиг хэргийн материал	211,000.00	127,500.00
35420	Аж ахуйн материал	1,755,850.00	16,200.00
35460	Хүнсний материал	873,220.00	85,360.00
35470	Бусад хангамжийн материал	7,102,201.07	6,738,001.07
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,344,821,421.01	1,312,482,160.62
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,344,821,421.01	1,312,482,160.62
392	Биет хөрөнгө	867,952,045.94	835,750,285.51
39201	Барилга, байгууламж, орон сууц	829,029,732.61	829,029,732.61
39202	Хуримтлагдсан элэгдэл	(37,109,431.92)	(55,955,481.24)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	84,869,985.46	87,735,485.46
39206	Хуримтлагдсан элэгдэл	(47,559,403.79)	(58,634,190.94)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	65,108,678.47	65,108,678.47
39208	Хуримтлагдсан элэгдэл	(44,950,193.51)	(48,833,479.95)
39209	Зам, гүүрийн байгууламж	21,088,953.66	21,088,953.66
39210	Хуримтлагдсан элэгдэл	(2,526,275.04)	(3,789,412.56)
393	Биет бус хөрөнгө	476,869,375.07	476,731,875.11
39301	Програм хангамж	550,000.00	550,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(240,624.93)	(378,124.89)
39303	Бусад биет бус хөрөнгө	476,560,000.00	476,560,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	1,428,752,490.84	1,393,184,320.45
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	-	423,375.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	-	423,375.00
413	Өглөг	-	423,375.00
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	-	423,375.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,428,752,490.84	1,392,761,332.45
51	Засгийн газрын хувь оролцоо	1,428,752,490.84	1,392,761,332.45
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	914,350,841.00	914,350,841.00
51101	Өмч: - төрийн	437,790,841.00	437,790,841.00
512	Хуримтлагдсан үр дүн	(89,160,073.92)	(125,151,232.31)
51210	Өмнөх үеийн үр дүн	(89,160,073.92)	(89,160,073.92)
51220	Тайлант үеийн үр дүн	-	(35,991,158.39)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	603,561,723.76	603,561,723.76
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1,428,752,490.84	1,393,184,320.45

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	709,121,705.00	647,618,250.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	47,672,705.00	5,601,850.00
120	Нийтлэг татварын бус орлого	47,672,705.00	5,601,850.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	47,672,705.00	5,601,850.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	47,672,705.00	5,601,850.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	661,449,000.00	642,016,400.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	606,644,300.00	586,361,700.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	606,644,300.00	586,361,700.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	850,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	500,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	350,000.00
131106	Төсвийн урамшуулал		
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	54,804,700.00	54,804,700.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	54,804,700.00	54,804,700.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	703,000,612.31	683,609,408.39
21	УРСГАЛ ЗАРДАЛ	703,000,612.31	683,609,408.39
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	682,426,491.33	667,918,815.06
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	489,353,280.67	491,230,097.61
210101	Үндсэн цалин	325,366,635.36	368,026,784.00
210102	Нэмэгдэл	123,617,797.31	85,358,521.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	3,360,000.00	1,236,944.61
210104	Урамшуулал	37,008,848.00	36,607,848.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	61,652,000.00	64,288,237.79
210201	Тэтгэврийн даатгал	42,121,325.54	46,095,050.47
210202	Тэтгэмжийн даатгал	4,956,100.69	4,608,907.01
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,907,758.28	3,608,167.59
210204	Ажилгүйдлийн даатгал	969,564.43	904,214.39
210205	Эрүүл мэндийн даатгал	9,697,251.06	9,071,898.33
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	38,796,577.84	37,827,790.27
210301	Гэрэл, цахилгаан	3,427,093.94	4,229,926.52
210302	Түлш, халаалт	26,136,479.86	27,084,868.75
210303	Цэвэр, бохир ус	9,233,004.04	6,512,995.00
2104	Хангамж, бараа материалын зардал	18,716,050.00	8,604,119.00
210401	Бичиг хэрэг	3,654,390.00	1,094,850.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	338,000.00	340,749.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	6,860,640.00	2,861,370.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,054,800.00	2,073,650.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	10,000.00	-
210408	Бараа материал акталсны зардал	4,798,220.00	2,233,500.00
2105	Нормативт зардал	36,370,660.00	25,859,310.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	206,200.00	90,680.00
210502	Хоол, хүнс	35,292,960.00	25,506,830.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	871,500.00	261,800.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	496,700.00	2,284,200.00
210604	Урсгал засвар	496,700.00	2,284,200.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	818,900.00	15,500.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	15,500.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	818,900.00	-

2109	Бараа үйлчилгээний бусад зардал	36,222,322.82	37,809,560.39
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,642,050.00	2,604,800.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	33,580,272.82	35,204,760.39
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	20,574,120.98	15,690,593.33
2132	Бусад урсгал шилжүүлэг	350,000.00	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	350,000.00	-
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	15,511,422.16	14,692,709.73
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	15,511,422.16	14,692,709.73
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	4,712,698.82	997,883.60
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	4,712,698.82	997,883.60
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	6,121,092.69	(35,991,158.39)
145	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	-	-
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	1,913,150.00	-
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	1,913,150.00	-
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	(1,913,150.00)	-
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	4,207,942.69	(35,991,158.39)

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	914,350,841.00	603,561,723.76	(93,378,016.61)	1,424,534,548.15
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	914,350,841.00	603,561,723.76	(93,378,016.61)	1,424,534,548.15
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	4,217,942.69	4,217,942.69
C08	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	914,350,841.00	603,561,723.76	(89,160,073.92)	1,428,752,490.84
D01	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	914,350,841.00	603,561,723.76	(89,160,073.92)	1,428,752,490.84
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	914,350,841.00	603,561,723.76	(89,160,073.92)	1,428,752,490.84
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	(35,568,170.39)	(35,568,170.39)
D09	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	914,350,841.00	603,561,723.76	(124,728,244.31)	1,393,184,320.45

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	663,062,655.00	659,933,318.00
11	ТАТВАРЫН ОРЛОГО	-	-
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	663,062,655.00	659,933,318.00

1310	Улсын төвлөрсөн төсвөөс	606,644,300.00	586,361,700.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	606,644,300.00	586,361,700.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	850,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	500,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	350,000.00
131106	Төсвийн урамшуулал		
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	54,804,700.00	54,804,700.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	54,804,700.00	54,804,700.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	1,613,655.00	17,916,918.00
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	1,613,655.00	17,916,918.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	663,062,655.00	659,933,318.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	663,062,655.00	659,933,318.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	640,874,879.02	626,325,806.67
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	489,346,831.18	490,807,109.61
210101	Үндсэн цалин	325,360,185.87	301,163,391.00
210102	Нэмэгдэл	124,018,857.31	151,527,635.61
210103	Унаа хоолны хөнгөлөлт	3,360,000.00	1,508,235.00
210104	Урамшуулал	36,607,788.00	36,607,848.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	61,652,000.00	64,288,237.79
210201	Тэтгэврийн даатгал	42,121,325.54	46,095,051.00
210202	Тэтгэмжийн даатгал	4,956,100.69	4,608,907.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,907,758.28	3,601,166.00
210204	Ажилгүйдлийн даатгал	969,564.43	904,214.00
210205	Эрүүл мэндийн даатгал	9,697,251.06	9,078,899.79
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	38,796,577.84	37,827,790.27
210301	Гэрэл, цахилгаан	8,272,240.94	4,229,926.52
210302	Түлш, халаалт	21,291,332.86	27,084,868.75
210303	Цэвэр, бохир ус	9,233,004.04	6,512,995.00
2104	Хангамж, бараа материалын зардал	8,297,190.00	2,647,499.00
210401	Бичиг хэрэг	193,400.00	413,250.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	156,700.00	340,749.00
210404	Ном, хэвлэл	120,700.00	-
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	7,426,840.00	1,421,200.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	399,550.00	472,300.00
2105	Нормативт зардал	38,072,410.00	25,680,770.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	206,200.00	90,700.00
210502	Хоол, хүнс	36,798,710.00	24,718,970.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,067,500.00	871,100.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	496,700.00	2,284,200.00
210604	Урсгал засвар	496,700.00	2,284,200.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	818,900.00	15,500.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	15,500.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	818,900.00	-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	3,394,270.00	2,774,700.00

210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,394,270.00	2,774,700.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	22,187,775.98	33,607,511.33
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,963,655.00	17,916,918.00
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	1,613,655.00	17,916,918.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	350,000.00	-
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	15,511,422.16	14,692,709.73
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	15,511,422.16	14,692,709.73
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	4,712,698.82	997,883.60
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	4,712,698.82	997,883.60
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	=	=
	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	=	=
	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	=	=
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-	-
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		415.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	415.00	415.00

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Өмнөх оны		Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	665,462,500	644,619,149	641,166,500	625,475,807
21	УРСГАЛ ЗАРДАЛ	665,462,500	644,619,149	641,166,500	625,475,807
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	665,112,500	644,269,149	641,166,500	625,475,807
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	489,369,700	489,346,831	491,015,800	490,807,110
210101	Үндсэн цалин	322,943,200	325,360,186	258,529,300	301,163,391
210102	Нэмэгдэл	126,967,700	124,018,857	189,637,900	151,527,636
210103	Унаа хоолны хөнгөлөлт	3,360,000	3,360,000	4,018,200	1,508,235
210104	Урамшуулал	36,098,800	36,607,788	38,830,400	36,607,848
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	61,652,000	61,652,000	64,603,300	64,288,238
210201	Тэтгэврийн даатгал	42,195,400	42,121,326	44,802,600	46,095,051
210202	Тэтгэмжийн даатгал	4,864,200	4,956,101	4,950,300	4,608,907
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,891,300	3,907,758	3,960,100	3,601,166
210204	Ажилгүйдлийн даатгал	972,800	969,564	990,000	904,214
210205	Эрүүл мэндийн даатгал	9,728,300	9,697,251	9,900,300	9,078,900

2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	52,520,500	38,796,578	52,520,500	37,827,790
210301	Гэрэл, цахилгаан	19,014,300	8,272,241	19,014,300	4,229,927
210302	Түлш, халаалт	19,339,000	21,291,333	19,339,000	27,084,869
210303	Цэвэр, бохир ус	14,167,200	9,233,004	14,167,200	6,512,995
2104	Хангамж, бараа материалын зардал	11,612,600	8,297,190	1,797,500	1,797,499
210401	Бичиг хэрэг	193,400	193,400	157,800	63,250
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	338,700	156,700	127,800	340,749
210404	Ном, хэвлэл	121,000	120,700	98,700	-
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	10,611,300	7,426,840	827,200	921,200
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	348,200	399,550	586,000	472,300
2105	Нормативт зардал	38,072,600	38,072,410	25,993,700	25,680,770
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	206,200	206,200	90,700	90,700
210502	Хоол, хүнс	36,798,800	36,798,710	25,031,900	24,718,970
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,067,600	1,067,500	871,100	871,100
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,284,200	496,700	2,284,200	2,284,200
210604	Урсгал засвар	2,284,200	496,700	2,284,200	2,284,200
2107	Томилолт, зочны зардал	197,700	-	161,300	-
210702	Дотоод албан томилолт	197,700		161,300	-
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	5,389,700	4,213,170	15,500	15,500
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	4,013,500	3,394,270	15,500	15,500
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,376,200	818,900		
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	4,013,500	3,394,270	2,774,700	2,774,700
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	612,800			
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,400,700	3,394,270	2,774,700	2,774,700
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	350,000	350,000	-	-
2132	Бусад урсгал шилжүүлэг	350,000	350,000	-	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	350,000	350,000		
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	661,449,000	641,224,879	641,166,400	25,475,807
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	606,644,300	601,931,601	586,361,700	585,363,816
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	606,644,300	601,931,601	586,361,700	585,363,816
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	54,804,700	39,293,278	54,804,700	40,111,990
132001	Орон нутгийн төсвөөс	54,804,700	39,293,278	54,804,700	40,111,990
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		-		-
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		415.00		-
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ				
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1.00	1.00	1.00	1.00

610001	Төсвийн байгууллага	1.00	1.00	1.00	1.00
610002	Төсвөөс гадуур байгууллага				
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	42.00	42.00	42.00	42.00
620001	Удирдах ажилтан	1.00	1.00	1.00	1.00
620002	Гүйцэтгэх ажилтан	29.00	29.00	29.00	29.00
620003	Үйлчлэх ажилтан	12.00	12.00	12.00	12.00
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	-	-	42.00	42.00
650004	СЭБ болон бага, дунд боловсролын албан хаагч (ТҮБД)	-	-	27.00	27.00
650008	Эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮЭМ)	-	-	1.00	1.00
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	-	-	14.00	14.00

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	-	850,000.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	-	850,000.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	-	850,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	-	850,000.00
210401	Бичиг хэрэг	-	350,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	-	500,000.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	-	850,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	850,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	500,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	350,000.00

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу 17 дугаар цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд төсвийн санхүүгийн тайлагнал, бүртгэл хөтлөлттэй холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Орхон аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Б.Бямбатогтох гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Б.Эрдэнэ, дарга, тэргүүлэх аудитор Ц.Нармандах нар тус тус хэрэгжүүлсэн.

17 дугаар цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Орхон аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 04 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

17 дугаар цэцэрлэг нь бага насны хүүхдийг өөрийн онцлог, чадвар, бүтээлч үйлээрээ хөгжин, насан туршийн боловсролын суурь чадварыг эзэмшихэд дэмжин асрах, хамгаалах, хөгжүүлэх, сургалт, үйл ажиллагаагаар сургуулийн өмнөх боловсрол эзэмшүүлэх байгууллага юм.

Сургалт, үйл ажиллагааны чанарыг сайжруулахад багш ажилтнуудын мэргэжлээрээ тасралтгүй хөгжих үйлийг дэмжих, сургалтын орчныг сайжруулах замаар хүүхдийн сурах үйлийг дэмжиж, цэцэрлэгт тасралтгүй бүрэн хамрагдахад эцэг эх, асран хамгаалагчдын оролцоо, хамтын ажиллагааг өргөжүүлж, тэдний хөгжил төлөвшилд ахиц гаргах зорилготой, дараах зорилтуудыг дэвшүүлэн ажиллажээ.

- Хамран сургах тойргийн хүүхдийг боловсролын үйлчилгээнд тэгш хамруулан сургах, сургалтын үйл ажиллагааг тасалдахаас урьдчилан сэргийлэх хариу арга хэмжээ авч онцгой нөхцөл байдлыг даван туулах нөхцөл бүрдүүлэх
- Сургалтын үйл ажиллагааг гэнэтийн буюу давагдашгүй хүчин зүйлийн үед тасралтгүй үргэлжлүүлэх бэлэн байдлыг хангаж, онцгой нөхцөл байдал үүссэн тохиолдолд танхимын бус сургалтыг хүртээмжтэй чанартай зохион байгуулах, талуудын оролцоо, хамтын ажиллагааны бэлэн байдлыг хангах
- Багш ажилтныг мэргэжлээрээ хөгжих, нөхцөл боломжийг бүрдүүлэх, тэдний тасралтгүй хөгжих үйлийг дэмжих
- Хүүхэд хамгааллын бодлогыг бүхий л түвшинд хэрэгжүүлэх орчныг бүрдүүлэх, онцгой нөхцөл байдлын үед сургалт үйл ажиллагааг явуулах нөхцөл боломжийг бүрэн хангаж ажиллах
- Эцэг эх олон нийтийн оролцоог дэмжиж, төрийн болон ТББ-тай хамтран ажиллах, олон нийтийн оролцоот үйл ажиллагааг хөгжүүлэх
- Сургалтын орчныг стандарт шаардлагад нийцүүлэх, аливаа эрсдэлээс урьдчилан сэргийлэх ажлыг үр дүнтэй зохион байгуулж, хүүхдэд ээлтэй тав тухтай орчныг бүрдүүлэн ажиллах.

Тайлант хугацаанд Төрийн албаны тухай хууль, Төсвийн тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Татварын хууль тогтоомж, Нийгмийн даатгалын тухай хууль тогтоомж, ТБОНӨХБАҮХАТХууль зэрэгт өөрчлөлт орсон байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Тус байгууллагад дотоод аудитын нэгж, хариуцсан ажилтан ажилладаггүй байна.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

17 дугаар цэцэрлэг 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр тайлант оны батлагдсан төсвийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны батлагдсан төсөв 641,166.4 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 9,617.5 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 7,213.1 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

17 дугаар цэцэрлэгийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 35,568.2 мянган төгрөгөөр буюу 2.5 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлттэй гарсан бараа материал, үндсэн хөрөнгө, өр төлбөрийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	0.0	0.0	0.0
Бараа материал	83,338.6	80,109.7	(3,228.9)
Үндсэн хөрөнгө	1,344,821.4	1,312,482.2	(32,339.2)
Нийт хөрөнгө	1,428,752.5	1,393,184.3	(35,568.2)
Өр төлбөр		423.0	423.0
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	1,428,752.5	1,393,184.3	(35,568.2)
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	1,428,752.5	1,393,184.3	(35,568.2)

Бараа материалын данс 80,109.7 мянган төгрөг болж 3,228.9 мянган төгрөгөөр буурсан нь тусгай зориулалтын материал акталснаас шалтгаалсан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 1,312,482.2 мянган төгрөг болж 32,339.2 мянган төгрөгөөр буурсан нь тайлант онд томоохон хөрөнгө бүртгээгүй, 132,385.9 мянган төгрөгийн хуримтлагдсан элэгдэл тооцсонтой холбоотой байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл 423.0 мянган төгрөг болж нэмэгдсэн нь ажилчдад өгөх өглөг үүссэнтэй холбоотой байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 1,393,184.3 мянган төгрөг болж 35,568.2 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ.

17 дугаар цэцэрлэгийн санхүүгийн үр дүнгийн тайлангаарх нийт орлого өмнөх оноос 61,503.5 мянган төгрөгөөр буюу 8.7 хувиар буурсан, нийт зардал өмнөх оноос 19,814.2 мянган төгрөгөөр буюу 3.6 хувиар тус тус буурсан байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

17 дугаар цэцэрлэг нь 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 914,312.5 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 914,312.5 мянган төгрөгөөр тооцож, төлөвлөн төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлсэн байна.

Тус байгууллагаас хүргүүлсэн төсвийн төслийг 268,577.5 мянган төгрөгөөр бууруулан 645,735.0 мянган төгрөгөөр баталсан байна. Тайлант онд төсөвт 1 удаа тодотгол хийж 4,568.6 мянган төгрөгөөр бууруулж, 641,166.4 мянган төгрөгөөр баталжээ. Тодотголоор нормативт зардлыг бууруулжээ.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх сургуулийн өмнөх боловсрол олгох үйл ажиллагааг хэрэгжүүлэхээр 586,361.7 мянган төгрөгийг улсын төсвөөс тусгай зориулалтын шилжүүлгээр, орон нутгийн төсвөөс 54,804.7 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 625,475.8 мянган төгрөгийг зарцуулж, 15,690.6 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 625,475.8 мянган төгрөг буюу 97.5 хувьтай байгаа нь цалин хөлс, нэмэгдэл урамшууллын зардлыг 208.7 мянган төгрөг, ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэлийн зардлыг 315.1 мянган төгрөг, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 14,692.7 мянган төгрөг, нормативт зардлыг 312.9 мянган төгрөг, томилолт зочны зардлыг 161.3 мянган төгрөгөөр дутуу зарцуулсантай холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Аймгийн БСУГ-аас 350.0 мянган төгрөгийн бичиг хэрэг, 500.0 мянган төгрөгийн хог хаягдал зайлуулах санхүүжилтийг нэмэлт санхүүжилтийн дансаар хүлээн авсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Тайлант онд ковид-19 халдварт цар тахалтай холбоотой хязгаарлалт үргэлжилсэн хэдий ч аудит хийх цар хүрээ хязгаарлагдаагүй болно.

3.8 Аудитын гол асуудал

Тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад нөлөө үзүүлэх асуудлууд үүсээгүй байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1-д хамаарах төсөвт байгууллага нь тус хуулийн 6.1, 6.4-т тус тус заасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

17 дугаар цэцэрлэг нь 2021 онд нийт 637,779.2 мянган төгрөгийн 151 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 2 мэдээллийг мэдээлэх хугацаа болоогүй, 637,779.2 мянган төгрөгийн 149 мэдээллийг ил тод байршуулж, хуулийн хугацаанд мэдээлсэн байна.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн, харин ур чадварын нэмэгдэл, үр дүнгийн урамшууллыг илүү тооцоолж олгосон нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх заалт, үндсэн хөрөнгийн тооллогыг үр дүнтэй зохион байгуулаагүй нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 72 дугаар зүйлийн 72.4 дэх заалттай тус тус нийцээгүй байна гэж дүгнэлээ.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар “Итгэл” үзүүлсэн байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудал байхгүй байна.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 2,615.5 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 423.4 мянган төгрөгийн алдааг залруулж, 268.6 мянган төгрөгт 1 төлбөрийн акт, 1,923.9 мянган төгрөгийн алдаа зөрчилд 2 зөвлөмж өгсөн.

4.1 Залруулсан алдаа

НДШ-н 1%-н шимтгэлийн зөрүүг ажилчдад олгоогүй, лист бодож олгохдоо зөрүүтэй тооцоолж олгосон 423.4 мянган төгрөгийг аудитын явцад залруулж ажилчдад өгөх өглөгөөр тусгаж тайлагнуулав.

4.2 Төлбөрийн акт

1. Төсвийн зарцуулалттай холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

Ур чадварын нэмэгдлийг 2 албан хаагчид 203.1 мянган төгрөгийг илүү тооцоолж олгосон, үр дүнгийн урамшууллыг 1 албан хаагчид 65.5 мянган төгрөгийг илүү олгосон байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах” гэсэн заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоов.

4.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Төсвийн зарцуулалттай холбоотой асуудал

1.1 Илрүүлэлт:

Үндсэн хөрөнгийн тооллого хийхдээ эд хариуцагчийн картаар тоолоогүй, тооллогын бүртгэлийг баталгаажуулаагүй, актлах бараа материалын жагсаалтыг гаргаагүй байна. Энэ Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 72 дугаар зүйлийн 72.4.1-д “эд хөрөнгийн тооллогыг тогтоосон хугацаанд үнэн зөв, чанартай явуулж дуусгах”, 72.4.4-д “комиссын хурлаар тооллогын үр дүнг хэлэлцэж, тооллогын бүртгэлийг баталгаажуулж, холбогдох акт, материалын хамт ерөнхий нягтлан бодогчид тусгай жагсаалтаар шилжүүлэн өгөх” гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

1.2 Өгсөн зөвлөмж:

Үндсэн хөрөнгийн тооллогыг хийхдээ эд хариуцагчийн картаар тоолж, актлах хөрөнгө, бараа материалын жагсаалтыг гаргаж өмч хамгаалах зөвлөлд хүргүүлэх.

2 Нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой асуудал

2.1 Илрүүлэлт:

Илүү цагийг тооцоолж олгохдоо Засгийн газрын 382 дугаар тогтоолын 2-р хавсралтаар батлагдсан “Төрийн захиргааны болон төрийн үйлчилгээний албан хаагчдад нэмэгдэл хөлс олгох журам”-г баримталж ажиллаагүй, ээлжийн амралттай байх хугацаанд илүү цаг олгосон байна. Энэ нь Засгийн газрын 382 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар батлагдсан “Төрийн захиргааны болон төрийн үйлчилгээний албан хаагчдад нэмэгдэл хөлс олгох журам”-ын 2.1-д “Нэмэгдэл хөлсийг төрийн албан хаагчийн ажилласан тухайн сарын цалин хөлсийг үндэслэн тодорхойлно. Тухайлбал, төрийн албан хаагч 2018 оны 8 дугаар

сард 6 цаг илүү ажилласан гэж үзвэл, тухайн ажилтны 8 дугаар сарын цалин хөлсийг үндэслэж, илүү цагийн хөлсийг тооцно” гэсэн заалттай нийцэхгүй байна.

2.2 Өгсөн зөвлөмж:

Илүү цагийг холбогдох журамд нийцүүлэн олгож байх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	17 дугаар цэцэрлэг	1	268.6			1	268.6				
2	17 дугаар цэцэрлэг	1								1	0
3	17 дугаар цэцэрлэг	1	1,923.9							1	1,923.9
4	17 дугаар цэцэрлэг	1	423.0	1	423.0						